



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 9/359

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийн
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн тусгай зөвшөөрлийн хугацаа 2020 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр дууссан тул боловсрол эзэмшүүлэх сургалтын хугацаатай уялдуулан сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 9 жилээр буюу 2029 оны 9 дүгээр сарын 29-ийг хүртэл сунгасугай.

2. Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу чанар, хүртээмжтэй зохион байгуулахыг тус сургуулийн Захирал (Ч.Болормаа)-д, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Өнөрцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

